

Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны
гарын авлагын 3 дугаар хавсралт



БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 21001:2018

ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ ЯВЦЫН УРСГАЛ ДИАГРАММ

БАЙГУУЛЛАГЫН НЭР	Монгол улсын их сургууль (МУИС)
БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ	Их сургуулийн гудамж – 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
БАРИМТ БИЧГИЙН №	NUM/EOMS/PFC/003
ХУВИЛБАР №	01
БОЛОВСРУУЛСАН ОГНОО:	2025-10-01


НЭГ.ЗОРИЛГО

Энэхүү үйл явцаар элсэлтийн журам боловсруулах, хөтөлбөрүүдэд хамрагдах оюутныг оновчтой сонгох, хуваарилах зэрэг хэвшсэн үйл явцыг бий болгох, хэрэгжүүлэхэд оршино. Түүнчлэн дотоодын болон гадаад оюутнуудад зориулсан хөтөлбөрүүдэд хамаарах элсэлтийн шаардлагыг мөрдөх үйл явцыг стандартчилна. Журам нь бүх хүсэлт гаргагчидтай ил тод, адил тэгш, шударга харьцах нөхцөлийг бүрдүүлнэ.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ


Журам нь МУИС-ийн хэрэгжүүлдэг бакалаврын болон ахисан түвшний хөтөлбөрийн элсэлтийн үйл явцад хамаарна.

ГУРАВ.ҮЙЛ ЯВЦЫН УРСГАЛ ДИАГРАММ



Элсэлтийн үе шат:





ДӨРӨВ.ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ ЯВЦЫН ХАНДЛАГА

№	Үе шат	Норматив эшлэл	Хариуцах
Элсэлтийн бодлого			
1	Их сургуулиас санал болгож буй бүх хөтөлбөрийн элсэлтийн бодлогыг хичээлийн жил бүр тогтоож, удирдлагад хянуулж, элсэлтийн журмыг шинэчлэн батална.	Элсэлтийн журам	СХЧБГ
2	Элсэлтийн бодлогыг дотоод, гадаад сонирхогч талуудад мэдээлнэ.	Вэб хуудсанд холбогдох журмыг нээлттэй байршуулах	СХЧБГ
3	Хичээлийн жил бүр оюутны элсэлтийн удирдамж/гарын авлагыг бэлтгэж, тараана.	Гарын авлага	СХЧБГ
Сонгон шалгаруулах үйл явц			
4	Сонирхсон оюутнуудыг элсүүлэхийн тулд боловсролын үзэсгэлэн яармаг, нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна. Хариуцсан нэгж элсэлтийн үйл явц, үе шатыг (офлайн элсэлтийн үйл явц бол) төлөвлөж, сонирхогч талд мэдээлнэ.	Удирдамж	СХЧБГ
5	Элсэх хүсэлтээ гаргасан бүртгүүлэгч элсэлтийн журмын шаардлагын дагуу сонгон шалгаруулалтад оролцоно.		ЦШГ, СХЧБГ
6	Хуваарь олгох өдөр шаардлагатай бүх зохицуулалтыг төлөвлөж, хянана. Элсэлтийн комисс, оролцох багш нарыг тодорхойлж, урьдчилан мэдэгдэнэ.	Сургалт, удирдлагын мэдээллийн систем	ЦШГ, СХЧБГ, Элсэлтийн комисс
7	Элсэх эрх олгох үйл ажиллагааг тодорхойлсон шалгуурын дагуу Сургалт, удирдлагын мэдээллийн системээр зохион байгуулна. Хяналтын тоо үлдсэн тохиолдолд нөхөн элсэлтийг Элсэлтийн комиссын шийдвэрээр зохион байгуулж болно.		ЦШГ, СХЧБГ, Элсэлтийн комисс
Элсэлтийн шалгалтын дүнг танилцуулах			
8	Элсэлтийн комисс элсэлтийн үйл явцыг хянана. Элсэлтийн бодлогод тодорхойлсон элсэлтийн шалгуур, мөн элсэлтийн шалгалтын дүнг үндэслэн хүсэлт гаргагчдыг тэнцсэн, хүлээлгийн жагсаалтад орсон, татгалзсан хэмээн ангилна.		ЦШГ, Элсэлтийн комисс
9	Элсэлтийн шалгалтын дүнгээр хүсэлт гаргагчдыг элсэлтийн портал дээр - Хяналтын тоонд багтсан Хяналтын тоонд багтаагүй Үлдсэн хяналтын тоо, одоогийн эзэлж буй байрыг харах Тэнцээгүй/татгалзсан хэмээн мэдээлнэ.		ЦШГ Элсэлтийн комисс

10	Тэтгэлэгтэй, олимпиад, спортын өндөр ур чадвар зэрэг тусгай нөхцөлөөр элсэх бол хүсэлт гаргагч холбогдох материалыг бүрдүүлж Элсэлтийн комисст өгнө		Элсэлтийн комисс
11	Элсэлтийн комисс тэнцсэн хүсэлт гаргагч бүрд мэдээллийг цахим шуудангаар болон холбогдох утсаар мэдэгдэнэ.		Элсэлтийн комисс
Оюутны оролцооны арга хэмжээ			
12	Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, сонирхогч талуудыг оролцуулна.		ОХГ, СХЧБГ
13	Сонирхогч талуудад их сургуулийн үйл ажиллагаа, тэдний оролцооны талаар тогтмол мэдээлж байна.		ОХГ, СХЧБГ
14	Оюутнуудыг идэвхжүүлэх, хөгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.		ОХГ
Элсүүлж /бүртгэж авах			
15	Оюутан элсүүлэх журам, бичиг баримтын шаардлага, хураамж төлөх хугацаа болон бусад холбогдох мэдээллийг веб хуудсанд ил байршуулна.		СХЧБГ
16	Элсэлтийн нөхцөл байдлыг элсэлтийн комисс хянах бөгөөд элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчид оюутан болох эрх үүснэ.		СХЧБГ
17	Элсэгчдийн мэдээллийг элсэлтийн комисс холбогдох талуудад хуваалцана.		СХЧБГ
18	Оюутан элссэний дараа шаардлагатай бичиг баримтыг бүртгэлийн системд оруулна.\		СХЧБГ
Элсэлтийг цуцлах			
19	Элсэлт цуцлагдсан тохиолдолд элсэхээс татгалзсан гэж үзэн дараагийн бүртгүүлэгчид хяналтын тоо шилжинэ.		
20	Элсэлтийн комисс элсэлтийн үйл явцыг хянана.		
21	Элсэлттэй холбоотой асуудлыг элсэлтийн комиссын хурлаар шийдвэрлэнэ.		
Оюутан шилжүүлэх			
22	Шилжүүлэн суралцуулах журмын шаардлага хангасан оюутан шилжих хүсэлтээ бүртгэлийн системээр гаргана.		
23	Шилжилтийн шалгалт нь суралцагч шилжүүлэх шалгалтыг зохион байгуулна		
24	Хяналтын тоонд багтаж тэнцсэн оюутны дүнгийн бичиг баримтыг хянаж, дүйцүүлэлтийг хийнэ.		
Элссэн оюутныг чиглүүлэх			
25	1 багц цагийн төлбөр төлж элсэх эрх баталгаажна.	СХЧБГ, ЦШГ	Төлбөрийн баримт
26	Товлосон хугацаанд 1 багц цагийн төлбөр төлж элсэх эрхээ системээр баталгаажуулна. Элсэх эрхээ авсны дараа оюутан болох эрхээ баталгаажуулна.	СХЧБГ, ЦШГ	Оюутны дугаар
27	Чиглүүлэх сургалтыг товлон суралцагчдад мэдэгдэнэ.	СХЧБГ, ОХГ	Чиглүүлэх хөтөлбөрийн хуваарь
28	Чиглүүлэх сургалт, цагийн хуваарь, үйл ажиллагааны төлөвлөгөөг ОХГ, СХЧБГ-аас боловсруулж, удирдлага батална.	СХЧБГ, ОХГ	Удирдамж РР
29	Чиглүүлэх сургалт, холбогдох материал, гарын авлагыг тараах		Тараах материал
30	Сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, эхлүүлэхэд зориулж хөтөлбөр бүрд элссэн оюутнуудын мэдээллийг холбогдох тэнхимүүдтэй хуваалцана.	Элсэлт хариуцсан мэргэжилтэн, СХЧБГ	Элсэлтийн тушаал

			Оюутны мэдээлэл
--	--	--	--------------------

ТАВ.ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Энэ үйл явцад холбоотой эрсдэлийг тодорхойлж, баримтжуулан Эрсдэл ба боломжийн бүртгэлд тусгасан болно.

ЗУРГАА.ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (KPIS)

№	ГТҮ-ийн тодорхойлолт

ДОЛОО.ОРОЛТ/ГАРАЛТЫН МАТРИЦ

... оролт	оролт	Үйл явц	гаралт	Гаралтын холболт
	- Элсэгчийн бүрдүүлэх материал (өргөдөл, үнэмлэхийн хуулбар, мэдүүлэг, гэрчилгээ гэх мэт) - Элсэгчийн сонгох мэргэжил, хөтөлбөр - Элсэлтийн журам, шаардлага	- Бүртгэл хүлээн авах - Шалгалт авах / үнэлгээ хийх - Оролцогчдыг оноо, шалгуураар эрэмбэлэх - Сонгон шалгаруулах (тэнцсэн/тэнцэ эгүй) - Эцсийн жагсаалт батлах - Тэнцсэн элсэгчдэд мэдэгдэл хүргүүлэх	- Тэнцсэн, тэнцээгүй элсэгчдийн жагсаалт - Бүртгэгдсэн шинэ оюутнууд - Элсэгч бүрийн элсэлтийн үнэлгээ, оноо	- Элсэлтийн үйл явцыг сайжруулах санал, дүгнэлт - Дараагийн жилийн элсэлтийн журамд тусгах өөрчлөлт - Элсэгчдэд өгөх чиглэл, зөвлөмж (дахин бүртгэх, нэмэлт материал бүрдүүлэх гэх мэт) - Статистик мэдээлэл: элсэлтийн түвшин, өрсөлдөөн, мэргэжлийн эрэлт

НАЙМ.НОРМАТИВ ЭШЛЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Баримтын нэр	Баримтын №
1	Элсэлтийн бодлого	
2	Оюутны элсэлтийн удирдамж	

ЕС.МАЯГТЫН ЖАГСААЛТ

№	Бүртгэлийн нэр	Маягтын №
1		
2		

АРАВ.ХЯНАЛТЫН ТҮҮХ, ЗӨВШӨӨРӨЛ

Хувилбар №	Өөрчлөлт	Хянасан огноо	Өөрчлөлтийн шалтгаан	Өөрчлөлт хийсэн	Өөрчлөлтийг баталсан
00	Эх хувь	хх.хх.хх	---	---	----